

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

/2020 оны жилийн эцсийн байдлаар/

2021.01.27

Дархан

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гүйцэтгэлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 15 зорилтын 18 арга хэмжээ, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэгтгэсэн тайлан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээллийг болон Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн тайлан, тоон мэдээлэл, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 02 дугаар хуралдааны гишүүдээс өгсөн санал, зөвлөмжийг үндэслэн гүйцэтгэв.

Тус тайлангийн 10 арга хэмжээний хэрэгжилтийг нэмэлт мэдээлэл, материал, чанарын аргад үндэслэн сайжруулалтыг гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.2 дахь заалтын дагуу хэрэгжилтийг хувиар тооцож гаргалаа.

2020-2024 онд хэрэгжихээр тусгагдсан 10 арга хэмжээний хувьд 2020 онд хийж хэрэгжүүлэн, хүрсэн түвшинг тодорхойлж, үнэлгээг өгч ажиллалаа.

2021-2024 онд хэрэгжихээр тусгагдсан 8 арга хэмжээний хувьд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бусад баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтээр хүрсэн үр дүнг тайлагнаснаар хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2020 оны жилийн эцсийн байдлаар Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

Эдийн засгийн бодлогын 4 зорилтын 5 арга хэмжээ,

Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээ,

Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээ,

Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээ, нийт **15 зорилтын 18 арга хэмжээг** хяналтанд авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

“Алсын хараа-2050 /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020.05.07/, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл /УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол/-ийн хүрээнд УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хувьд 2020 онд батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг **зорилт; арга хэмжээ** –р нь үнэлж байгаагаараа онцлогтой байлаа.

Гурав. Дүгнэлт

2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний **15 зорилтын** хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **79.66%** буюу **3.98** онооны үнэлгээгээр үнэлэгдлээ.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс				
			III. Эдийн засгийн бодлого	IV. Засаглалын бодлого	V. Ногоон хөгжлийн бодлого	VI. Орон нутгийн хөгжлийн бодлого	
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	4	2	3	6	
2.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	4	1	1	2	-
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99.0%	9	2	-	1	6
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69.0%	2	1	1	-	-
		Үр дүнгүй буюу 0-30.0%	-	-	-	-	-
Хэрэгжилтийн дундаж хувь, оноо		79.66% буюу 3.98 оноо	73.75% буюу 3.68 оноо	75.0% буюу 3.75 оноо	96.66% буюу 4.83 оноо	76.66% буюу 3.83 оноо	

18 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр **81.67** хувийн хэрэгжилттэй **4.08** онооны үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс				
			III. Эдийн засгийн бодлого	IV. Засаглалын бодлого	V. Ногоон хөгжлийн бодлого	VI. Орон нутгийн хөгжлийн бодлого	
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	4	2	3	6	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	18	5	4	3	6	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	7	2	3	2	-
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90.0%	3	-	-	1	2
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	5	1	-	-	4
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	3	2	1	-	-
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	-	-	-	-	-
		Үр дүнгүй буюу 0.0%	-	-	-	-	-
Хэрэгжилтийн дундаж хувь, оноо		81.67% буюу 4.08 оноо	74.0% буюу 3.7 оноо	87.50% буюу 4.37 оноо	96.6% буюу 4.83 оноо	76.66% буюу 3.83 оноо	

Холбогдох зохицуулах салбарын зорилт, арга хэмжээгээр харуулбал:

- ✓ Эдийн засгийн бодлогын 4 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 74.0%,
- ✓ Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 87.50%,
- ✓ Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 96.66%,
- ✓ Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 76.66%-ийн үнэлгээтэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
			Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Санхүү төрийн сангийн хэлтэс	Цэргийн штаб	Захирагчийн алба	
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	1	9	1	1	1	2	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	18	1	10	1	1	3	2	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	7	-	4	-	-	3	-
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90.0%	3	-	3	-	-	-	-
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	5	-	2	1	1	-	1
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	3	1	1	-	-	-	1
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	-	-	-	-	-	-	-
		Үр дүнгүй буюу 0.0%	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийн хувь, оноо		81.67% буюу 4.08 оноо	50.0% буюу 2.5 оноо	86.0% буюу 4.30 оноо	70.0% буюу 3.5 оноо	70.0% буюу 3.5 оноо	100% буюу 5.0 оноо	60.0% буюу 3.0 оноо	

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх зөвлөмж

Ололттой тал:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын талаарх үнэлгээг танилцуулж, шаардлагатай нэмэлт мэдээлэл, материалыг хэлтсүүдийн /Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн

мэргэжилтэн, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хэлтсийн дарга /холбогдох албан тушаалтнууд шуурхай мэдээлж хамтарч ажиллалаа,

Анхаарах асуудал /зөвлөмж/

1. Засгийн газрын 202012.09-ны өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг бүх албан хаагчид уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа дараах зөвлөмжийг онцгой анхаарах:
 - а/ бодит, үнэн зөв мэдээллийг бүрэн оруулах
 - б/ хүрэх буюу зорилтот түвшинтэйгээ уялдуулж 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах
 - в/ шаардлагатай тохиолдолд нотлох фото зураг, материалыг PDF хэлбэрээр хавсаргаж ирүүлэх,
2. Цахим сангийн хэрэгжилт хэсэгт “Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төг/-ийг тайлагнах боломжтой тул арга хэмжээ тус бүрийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг эх үүсвэрийн хамт тодорхой тусгаж ажиллахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН